ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2026 оны 11 дүгээр сарын 13
№42 (1437)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

380.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 70	3103

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

381.	Журам батлах тухай	Дугаар 253	3104
382.	Аргачлал баталж, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 296	3112

агуулга

Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол	10	3015
Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль	24	3017
Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	63	3019

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 10 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 70 | Улаанбаатар хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн нарын 31 гишүүнээс 2026 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.БЯМБАЦОГТ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 253 | Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1, 5.3.2 дахь заалтад заасан шаардлагыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангах, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгаж, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагуудын удирдлагад тус тус зөвлөсүгэй.

3.Мэргэжлийн нэгдсэн холбоог улсын бүртгэлд бүртгэхтэй холбоотой үйлчилгээг “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-business.mn)-ээр дамжуулан цахим хэлбэрээр үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Улсын бүртгэлийн ерөнхий газар (Д.Дабааням), “И-Монгол академи” УТҮГ (М.Баттулга)-т тус тус үүрэг болгосугай.

4.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайханд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.УЧРАЛ**

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА **Б.ЭНХБАЯР**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠑᠗ — ᠨ ᠡᠳᠦᠷ   ᠳᠤᠭᠠᠷ ᠒᠔᠓   ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠵᠤᠷᠪᠤᠰ ᠪᠠᠲᠤᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠔᠐ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑ ᠳᠡᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ᠂ ᠴᠠᠬᠢᠮ ᠬᠤᠳᠠᠯᠳᠤᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠑᠐ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑ ᠳᠡᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠢ ᠦᠨᠳᠦᠰᠦᠯᠡᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠠᠴᠠ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠬᠤ ᠨᠢ:

᠑. «ᠴᠠᠬᠢᠮ ᠪᠢᠽᠨᠧᠰ ᠦᠨ ᠲᠡᠷᠡᠭᠦᠦ ᠳᠦ ᠪᠦᠷᠢᠳᠭᠡᠯ ᠬᠥᠲᠦᠯᠬᠦ ᠵᠤᠷᠪᠤᠰ» — ᠢ ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠶᠣᠰᠣᠭᠠᠷ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠭᠠᠢ᠃

᠒. ᠴᠠᠬᠢᠮ ᠪᠢᠽᠨᠧᠰ ᠦᠨ ᠲᠡᠷᠡᠭᠦᠦ ᠳᠦ ᠪᠦᠷᠢᠳᠭᠡᠯ ᠬᠥᠲᠦᠯᠬᠦ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ ᠳᠤ ᠱᠠᠭᠠᠷᠳᠠᠭᠳᠠᠬᠤ ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢ ᠵᠢᠯ ᠪᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠲᠣᠰᠤᠪ ᠲᠤ ᠲᠤᠰᠭᠠᠨ ᠰᠠᠩᠬᠦᠦᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠶᠢ ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠰᠠᠢᠳ᠂ ᠡᠳ᠋ ᠦᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠬᠦᠭᠵᠢᠯ ᠦᠨ ᠰᠠᠢᠳ ᠲᠤ ᠳᠠᠯᠠᠯᠠᠭᠰᠠᠭᠠᠢ᠃

᠓. ᠴᠠᠬᠢᠮ ᠪᠢᠽᠨᠧᠰ ᠦᠨ ᠲᠡᠷᠡᠭᠦᠦ ᠳᠦ ᠪᠦᠷᠢᠳᠭᠡᠯ ᠬᠥᠲᠦᠯᠬᠦ ᠲᠠᠢ ᠬᠣᠯᠪᠣᠭᠳᠠᠬᠤ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ᠂ «ᠦᠢᠯᠡᠳᠪᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠪᠦᠷᠢᠳᠭᠡᠯ ᠦᠨ ᠰᠢᠰᠲ᠋ᠧᠮ» ᠢ ᠡᠭᠦᠳᠬᠦ ᠴᠠᠬᠢᠮ ᠪᠢᠽᠨᠧᠰ ᠦᠨ ᠰᠠᠶᠢᠲ᠋ (e – business. mn) – ᠲᠠᠢ ᠬᠣᠯᠪᠣᠬᠤ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ ᠶᠢ ᠭᠠᠳᠠᠭᠠᠳᠤ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠰᠠᠢᠳ (ᠪ᠂ ᠪᠠᠲᠤᠴᠡᠴᠡᠭ)᠂ «ᠮ᠊ — ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭ» ᠶᠢᠨ ᠬ᠂ ᠬ᠂ ᠬ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ ᠲᠠᠢ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠮᠵᠢ ᠶᠢᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ (ᠵ᠂ ᠪᠠᠲᠤᠪᠣᠯᠣᠳ)—ᠳᠤ ᠲᠤᠰ ᠲᠤᠰ ᠦᠦᠷᠡᠭ ᠳᠠᠯᠠᠯᠠᠭᠰᠠᠭᠠᠢ᠃

᠔. ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠳᠦ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠲᠠᠪᠢᠬᠤ ᠶᠢ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠷᠦᠩᠬᠡᠢ ᠰᠠᠢᠳ ᠤᠨ ᠵᠥᠪᠯᠡᠬᠦ (ᠨ᠂ ᠪᠠᠲᠤᠪᠠᠶᠠᠷ) ᠳᠤ ᠦᠦᠷᠡᠭ ᠳᠠᠯᠠᠯᠠᠭᠰᠠᠭᠠᠢ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠷᠦᠩᠬᠡᠢ ᠰᠠᠢᠳ   ᠨ᠂ ᠤᠴᠠᠷᠠᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠰᠠᠢᠳ᠂
ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ
ᠬᠡᠷᠡᠭ ᠡᠷᠬᠢᠯᠡᠬᠦ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ   ᠪ᠂ ᠤᠶᠤᠨᠪᠢᠯᠢᠭ

Засгийн газрын 2026 оны 06 дугаар
сарын 17-ны өдрийн 253 дугаар
тогтоолын хавсралт

МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООГ БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Мэргэжлийн нэгдсэн холбоог шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх (цаашид “улсын бүртгэлд бүртгэх” гэх)-тэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Мэргэжлийн нэгдсэн холбоо (цаашид “МНХ” гэх)-г улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг тус тус баримтална.

1.3.МНХ-г улсын бүртгэлд бүртгэх чиг үүргийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгж хэрэгжүүлнэ.

1.4.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д хамаарах салбар, дэд салбар бүрд нэг хүртэл МНХ байна.

1.5.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан эрх бүхий этгээд МНХ-г бүртгүүлэх хүсэлтийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад гаргана.

1.6.Улсын бүртгэлийн байгууллага МНХ-г улсын бүртгэлд бүртгэх эсэх шийдвэрийг Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан хугацаанд гаргаж, үндэслэл, тайлбарын хамт хүсэлт гаргагчид цаасан, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ.

1.7.Хүсэлт гаргах эрх бүхий этгээд МНХ-г улсын бүртгэлд бүртгүүлэхдээ Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн

21.1 дэх хэсэгт заасан улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс төлнө.

Хоёр.Мэргэжлийн нэгдсэн холбоог шинээр үүсгэн байгуулсныг бүртгэх

2.1.МНХ-г шинээр үүсгэн байгуулсныг улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагаанд Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 5, 6, 7, 8 дугаар зүйл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийг тус тус баримтална.

2.2.МНХ-г шинээр үүсгэн байгуулсныг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтэд Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан баримт бичгийг хавсаргана.

2.3.Улсын бүртгэгч МНХ-г бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийн бүрдлийг хянаж, зөрчил илэрсэн тохиолдолд хүсэлт гаргагчид цаасан, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

2.4.Хүсэлт гаргагч энэ журмын 2.3-т заасан зөрчлийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор баримт бичгийг хуульд нийцүүлэн ирүүлсэн тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага 21 хоногийн дотор улсын бүртгэлд бүртгэнэ.

Гурав.Мэргэжлийн нэгдсэн холбоог өөрчлөн байгуулсныг бүртгэх

3.1.МНХ-г өөрчлөн байгуулсныг улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагаанд Иргэний хуулийн 31 дүгээр зүйл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 19, 20, 21 дүгээр зүйлийг тус тус баримтална.

3.2.МНХ-г өөрчлөн байгуулсныг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтэд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан баримт бичгийг хавсаргана.

3.3.МНХ-г өөрчлөн байгуулсныг улсын бүртгэлд бүртгэхэд энэ журмын 2.3, 2.4-т заасан хугацааг баримтална.

Дөрөв.Мэргэжлийн нэгдсэн холбоог татан буулгасныг бүртгэх

4.1.МНХ-г татан буулгасныг улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагаанд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23, 24, 25 дугаар зүйлийг тус тус баримтална.

4.2.МНХ-г татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэж, шийдвэрийг мэдэгдэлд хавсаргана.

4.3.Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэгт заасны дагуу эрх бүхий этгээд МНХ-г татан буулгасан тухай нийтэд мэдээлснээс хойш хоёроос зургаан сарын дотор холбогдох баримт бичгийг бүрдүүлэн улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ.

4.4.МНХ-г татан буулгасныг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтэд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасан баримт бичгийг хавсаргана.

4.5.МНХ-г татан буулгасныг улсын бүртгэлд бүртгэхэд энэ журмын 2.3, 2.4-т заасан хугацааг баримтална.

4.6.МНХ-г татан буугдсан тухай мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэснээр улсын бүртгэлээс хасагдсанд тооцно.

Тав.Улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах

5.1.Улсын бүртгэгч Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлд тус тус зааснаас гадна дараах үндэслэлээр МНХ-г улсын бүртгэлд бүртгэхээс татгалзана:

5.1.1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан эрх бүхий этгээд хүсэлт гаргаагүй;

5.1.2.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1, 5.3.2 дахь заалтад заасан шаардлагыг хангаагүй;

5.1.3.улсын бүртгэлд бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу, эсхүл мэдээлэл нь зөрүүтэй, илт хуурамч;

5.1.4.улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс төлөөгүй;

5.1.5.улсын бүртгэлд хөдөлгөөн хийх эрхийг түдгэлзүүлсэн тухай эрх бүхий этгээдийн шийдвэр гарсан;

5.1.6.тухайн улсын бүртгэлийн асуудлаар хууль хяналтын байгууллагаас эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа;

5.1.7.улсын бүртгэлийн мэдээллийн санд эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбар, дэд салбарын ангилалд МНХ бүртгэлтэй бол ижил ангилалд бүртгүүлэхээр ирүүлсэн;

5.1.8.энэ журмын 2.4-т заасан хугацаанд зөрчлийн үндэслэлээ арилгаж, холбогдох баримт бичгийг ирүүлээгүй.

5.2.Улсын бүртгэгч энэ журмын 5.1-д заасан үндэслэлээр улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан тухай шийдвэрийг хуулийн этгээдийн хувийн хэрэгт хавсаргана.

5.3.Хүсэлт гаргагч энэ журмын 5.1-д заасан татгалзах үндэслэлийг арилгасны дараа улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг дахин гаргаж болно.

5.4.МНХ-г улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан тухай шийдвэрийг хүсэлт гаргагч үндэслэлгүй гэж үзвэл Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу гомдол гаргах эрхтэй.

Зургаа.Мэргэжлийн нэгдсэн холбооны мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэх

6.1.МНХ-ны мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагаанд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийг баримтална.

6.2.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан мэдээлэлд өөрчлөлт оруулсан шийдвэр, холбогдох баримт бичгийг тухайн МНХ ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ.

6.3.МНХ-ны мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтэд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасан баримт бичгийг хавсаргана.

6.4.МНХ-ны мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхэд энэ журмын 2.3, 2.4-т заасан хугацааг баримтална.

Долоо.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэхэд тавих шаардлагыг тогтоох

7.1.Улсын бүртгэлийн байгууллага Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт заасны дагуу МНХ-г улсын бүртгэлд бүртгэхэд шаардлагатай нэмэлт баримт бичиг, лавлагаа, мэдээлэл, тайлбарыг статистик, татвар, гааль, өрсөлдөөний асуудал эрхэлсэн байгууллага болон бусад холбогдох байгууллагаас гаргуулан авна.

7.2.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1, 5.3.2 дахь заалтад заасан шаардлагыг тогтооход тусгай мэдлэг, мэргэшил шаардлагатай тохиолдолд улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр шинжээч томилж болно.

7.3.Шинжээч нь тухайн ангиллын МНХ-ны эрх бүхий этгээдтэй Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5, 3.1.6, 3.1.11 дэх заалтад заасан хамааралгүй байна.

7.4.Шинжээч нь тогтоосон хугацаанд асуудлыг бүрэн, бодитой, хараат бусаар шинжилж, үнэн зөв дүгнэлтийг бичгээр гаргана.

7.5.Энэ журмын 7.2-т заасан шинжээчийн үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, ажлын хөлс тооцох аргачлалыг Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтад заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

7.6.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.2 дахь заалтад заасан гишүүдийн үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалт нь тухайн салбарын зах зээлийн 50-иас дээш хувийг эзэлж буй эсэх асуудлаар тухайн салбарын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий ажлын хэсэг байгуулж, санал, дүгнэлт гаргуулж болно.

7.7.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.2 дахь заалтад заасан шаардлагыг тогтоохдоо Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлсэн сүүлийн жилийн санхүү, татварын тайлан, статистикийн мэдээлэл болон шаардлагатай бусад баримт бичгийг үндэслэнэ.

7.8.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалтад заасан шаардлагыг тогтоохдоо Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасан хамаарал бүхий этгээдийн гишүүнчлэлийг нэгтгэн тооцно.

7.9.Улсын бүртгэл хөтлөхөд шаардлагатай төрийн бусад байгууллагын мэдээллийг нийтийн мэдээллийн дэд бүтцээс авч баталгаажуулна.

7.10.Улсын бүртгэлийн байгууллага Мэргэжлийн нэгдсэн холбооны улсын бүртгэл хөтлөхөд шаардлагатай мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагын мэдээллийн сангаас баталгаажуулна.

Найм.Гомдол, маргааныг хянан шийдвэрлэх

8.1.МНХ-ны улсын бүртгэлтэй холбоотой гомдол, маргааныг Захиргааны ерөнхий хууль болон Улсын бүртгэлийн ерөнхий хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 07 дугаар сарын 08-ны өдөр | Дугаар 296 | Улаанбаатар хот

Аргачлал батлаж, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулах аргачлал”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 20 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын хуралдааны журам”-д доор дурдсан агуулгатай 4.12, 4.13 дахь заалт нэмсүгэй:

“4.12.Засгийн газрын гишүүн хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд бие даан шийдвэрлэх асуудлыг хуралдаанаар хэлэлцэхгүй.

4.13.Засгийн газраас санаачлах хууль тогтоомжийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20.7, 20.8, 20.9-д тус тус заасан хүрээнд санхүү, төсвийн, хууль зүйн, гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус хянаж, хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл олгосны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.”.

3.Мөн журмын 11.4 дэх заалтад “Хуралдаанд танилцуулах асуудалд тодорхой асуудлыг шийдвэрлэх, хөрөнгө, санхүүжилт гаргах зохицуулалт тусгахыг хориглоно.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмсүгэй.

4.Мөн журмын 7.3.2 дахь дэд заалтын “энэ журмын 5.1-5.4-т” гэснийг ““Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулах аргачлал”-д” гэж, 7.4 дэх заалтын “энэ журамд” гэснийг “энэ журам болон Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулах аргачлалд” гэж тус тус өөрчилсүгэй.

5.Мөн журмын 10.3 дахь заалтын “5.1.1-5.1.6, 6.1-6.7,” гэснийг хассугай.

6.Мөн журмын Тав, Зургаа дахь бүлгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7.Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан аргачлалыг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаярт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД **Н.УЧРАЛ**

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА **Б.ЭНХБАЯР**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ

[illegible] ᠣᠨ ᠤ [illegible] ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ [illegible] — ᠤ ᠡᠳᠦᠷ ᠳᠤᠭᠠᠷ [illegible] ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

[illegible]

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠒᠐ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ [illegible] ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠠᠴᠠ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠬᠤ ᠨᠢ:

᠑. [illegible]

᠒. [illegible]

᠓. [illegible]

᠔. [illegible]

᠑.ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠒.᠓.᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ «ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠖.᠒ — ᠖.᠓ — ᠳᠤ» ᠭᠡᠳᠡᠭ ᠢ ««ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠖.᠒ ᠳᠤ» ᠭᠡᠵᠦ ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠤᠭᠰᠠᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠵᠦᠢ» — ᠳᠦ» ᠭᠡᠳᠡᠭ ᠢ «ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠒.᠒ ᠳᠤ» ᠭᠡᠵᠦ ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠤᠭᠰᠠᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠵᠦᠢ» ᠭᠡᠵᠦ ᠥᠭᠡ ᠥᠭᠡ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠨ ᠨᠡᠮᠡᠭᠰᠡᠭᠡᠢ::

᠒.ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠑᠐.᠓ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ «᠔.᠑.᠖ — ᠔.᠑.᠗, ᠕.᠑ — ᠕.᠒.» ᠭᠡᠳᠡᠭ ᠢ ᠬᠠᠰᠤᠭᠰᠤᠭᠠᠢ::

᠓.ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠪᠦᠯᠦᠭ. ᠵᠦᠢᠯᠴᠢᠯᠡᠯ ᠦᠨ ᠬᠦᠴᠦᠨ ᠦᠭᠡᠢ ᠥᠭᠡ ᠥᠭᠡ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠳᠤ ᠲᠣᠭᠠᠴᠠᠭᠰᠤᠭᠠᠢ::

᠒.ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ. ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠰᠣᠩᠭᠤᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠳᠠᠷᠠᠭ᠎ᠠ ᠵᠢᠯ ᠦᠨ ᠲᠠᠪᠤᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠨᠢᠭᠡᠨ ᠤ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠡᠨ᠎ᠡ::

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ
ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠣᠷᠣᠯᠠᠭᠴᠢ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠡᠳ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ

ᠪ.ᠪᠠᠶᠠᠷᠮᠠᠭᠨᠠᠢ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ
ᠳᠡᠳ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ

ᠵ.ᠰᠠᠢᠨᠪᠠᠶᠠᠷ

Засгийн газрын 2026 оны 07 дугаар
сарын 08-ны өдрийн 296 дугаар
тогтоолын хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү аргачлалын зорилго нь Засгийн газрын шийдвэрийн төслийг боловсруулахад баримтлах арга зүй, төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлж, Засгийн газрын хуралдааны шийдвэр ил тод, хууль зүйн үндэслэлтэй, үр дүнтэй, хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт заасан зорилго, зорилтыг хангахад чиглэсэн, хэрэгжих боломжтой байх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

1.2.Энэхүү аргачлалыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу дараах шийдвэр (цаашид “шийдвэр” гэх)-ийн төслийг боловсруулахад баримтална:

1.2.1.Засгийн газрын тогтоолын төсөл;

1.2.2.Ерөнхий сайдын захирамжийн төсөл.

1.3.Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг боловсруулах болон түүнд тавигдах шаардлагыг Засгийн газрын хуралдааны журмаар зохицуулна.

1.4.Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөл болон тэдгээрт холбогдох материалыг боловсруулахад Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актыг баримтална.

Хоёр.Шийдвэрийн төсөлд тавигдах шаардлага

2.1.Шийдвэрийн төсөл дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1.тухайн асуудлыг шийдвэрлэх бүрэн эрх Засгийн газар, Ерөнхий сайдад хууль тогтоомжоор олгогдсон байх;

2.1.2.Монгол Улсын Үндсэн хууль, Захиргааны ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, бусад

хууль тогтоомж, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн байх;

2.1.3.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт заасан зорилго, зорилтод нийцсэн байх;

2.1.4.авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх эрсдэл, шалтгаан, нөхцөлийг бүрдүүлээгүй, төрийн болон нийтийн ашиг сонирхолд нийцсэн, шийдвэрт тусгасан асуудлаар шийдвэр гаргах эрх нь хууль тогтоомжоор өөр байгууллага, албан тушаалтанд олгогдоогүй байх;

2.1.5.зохих тооцоо, судалгаанд үндэслэсэн, шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, зардлыг үндэслэлтэйгээр тооцсон, хэрэгжих боломжтой, санхүүжүүлэх эх үүсвэр тодорхой байх;

2.1.6.хуулийн заалтыг давхардуулаагүй, өмнө гарсан, хүчин төгөлдөр мөрдөж байгаа бусад шийдвэртэй зөрчил, давхардалгүй байх;

2.1.7.шийдвэрийн заалт болон тэдгээрт заасан арга хэмжээ нь хоорондоо зөрчил, давхардалгүй, логик дараалалтай, харилцан уялдаатай, хариуцлагын хэм хэмжээ заагаагүй байх;

2.1.8.хуулиар эрх олгоогүй тохиолдолд шинээр үүрэг, хориглолт, хязгаарлалт, хариуцлага, төлбөр, хураамж тогтоогоогүй байх;

2.1.9.хууль тогтоомж, өмнө гарсан шийдвэрт хэрэглэсэн үг хэллэг, нэр томьёог ашиглан энгийн, ойлгомжтой, хоёрдмол утгагүй боловсруулагдсан байх, шаардлагагүй, тодорхойгүй, албан бус үг хэллэг, нэр томьёо хэрэглээгүй байх;

2.1.10.Монгол хэлний зөв бичих дүрэм, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн С/30 дугаар тушаалаар батлагдсан “Баримт бичгийн стандарт MNS 5140:2021”, Засгийн газрын 2010 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 44 дүгээр тогтоолоор батлагдсан “Компьютерийн кирилл болон монгол үсгийн нэгдсэн кодын MNS-5552:2005 стандарт”, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 214 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-д нийцсэн байх;

2.1.11.шийдвэрийн хэрэгжилтийг хариуцах, биелэлтэд хяналт тавих байгууллага, албан тушаалтан, хэрэгжилтийг хэмжих шалгуур

үзүүлэлт, хэрэгжилтийг хангах болон тайлагнах хугацааг тодорхойлж, шаардлагатай бол төсөлд тусгасан байх;

2.1.12.шийдвэрийн төсөлд аливаа байгууллага, албан тушаалтанд үүрэг, даалгавар өгөх, чиглэл хүргүүлэх, зөвлөмж болгохоор тусгахдаа тухайн асуудал нь холбогдох байгууллага, албан тушаалтны хууль тогтоомжид заасан чиг үүрэг, бүрэн эрх, эрхлэх асуудлын хүрээнд нийцсэн байх;

2.1.13.хэд хэдэн Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн даргад даалгавар, үүрэг, чиглэл өгөх, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагад зөвлөмж болгох бол тухайн шийдвэрийн биелэлтийг голлон хариуцах буюу зохион байгуулах Засгийн газрын гишүүн, албан тушаалтныг эхэнд нь эрэмбэлж, түүний араас шийдвэрт хамаарах бусад Засгийн газрын гишүүд, албан тушаалтныг хууль тогтоомжид заасан чиг үүрэг, бүрэн эрхэд нь нийцүүлэн Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль, Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч, Төрийн өндөр албаны тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд заасан дараалаар байрлуулах;

2.1.14.шийдвэрийн төсөлд тусгасан асуудалд хамаарах холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт заасан бусад шаардлагыг хангасан байх.

2.2.Шийдвэрийн төслийн танилцуулгад дараах мэдээллийг тусгана:

2.2.1.шийдвэр гаргах хууль, эрх зүйн үндэслэл;

2.2.2.шийдвэрийн төсөл боловсруулах зорилго, үндэслэл, шаардлага, тухайн асуудлын нөхцөл байдал, шийдвэрлэх тулгамдсан асуудал, шийдвэр гарснаар үүсэх үр дагавар, түүнийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээ;

2.2.3.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцсэн байдал, зохих тооцоо, судалгаа, шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, зардлын тооцоо, санхүүжүүлэх эх үүсвэр, төсөвт үзүүлэх нөлөөлөл;

2.2.4.Засгийн газрын гишүүд, холбогдох байгууллагаас авсан санал, тэдгээрийг нэгтгэж, дүгнэсэн байдал;

2.2.5.Захиргааны хэм хэмжээний акт батлах шийдвэрийн хувьд энэ аргачлалын 2.3-т заасан шаардлагыг хангасан тухай мэдээлэл, нотломж;

2.2.6.шийдвэрийн хэрэгжилтийг хариуцах, биелэлтэд хяналт тавих байгууллага, албан тушаалтан, хэрэгжилтийг хэмжих шалгуур үзүүлэлт, хэрэгжилтийг тайлагнах хугацааны талаарх мэдээлэл;

2.2.7.шийдвэрийн төсөлд тусгасан асуудлаар өмнө гарсан шийдвэр, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн жагсаалт болон шаардлагатай бол тэдгээрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл;

2.2.8.шийдвэрийн төсөлд тусгасан асуудалд хамаарах холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт заасан бусад мэдээлэл.

2.3.Хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын шийдвэрээр батлах захиргааны хэм хэмжээний актын төсөл нь энэ аргачлалд зааснаас гадна Захиргааны ерөнхий хуулийн 59, 60, 61, 62, 63 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

2.4.Шийдвэрийн төсөлд тусгасан арга хэмжээ болон энэ аргачлалын 2.2-т заасан танилцуулгад тусгасан асуудал нь хоорондоо зөрчилгүй байна.

2.5.Шийдвэрийн төсөл, холбогдох материал нь албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, баримт бичгийн стандартаар тогтоосон загвар, хэмжээний дагуу материалыг хувилж олшруулах, архивын нэгж бүрдүүлэх, цахим хэлбэрээр архивлах шаардлагад нийцсэн байна.

2.6.Хууль болон Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.2, 38.4, 38.10, 39.3, 40.1.13, Зөвшөөрлийн тухай хуулийн 9.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан материал, нотлох баримтыг бүрдүүлж, хавсаргасан байна.

2.7.Шийдвэрийн төслийн эх бичвэрийг энэ аргачлалд нийцүүлэн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын холбогдох хэсгийг баримтлан боловсруулна.

Гурав.Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулах

3.1.Засгийн газрын тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хуульд заасан Засгийн газрын бүрэн эрхэд хамаарах асуудлаар, хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, тодорхой асуудлыг шийдвэрлэх чиглэлээр эрх зүйн үр дагавар бий болгосон захирамжилсан шийдвэрийн хэлбэрээр боловсруулна.

3.2.Засгийн газрын хуралдааны журамд заасан Засгийн газрын хуралдаанаар танилцах асуудлаар холбогдох албан тушаалтанд даалгавар, үүрэг, чиглэл өгөх, Засгийн газрын харьяа байгууллагуудад хамаарах зохион байгуулалтын шинжтэй болон Засгийн газрын гишүүний бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулахгүй.

3.3.Засгийн газрын тогтоолын төсөл дараах шаардлагыг хангасан байна:

3.3.1.“Монгол Улсын Засгийн газрын тогтоол” гэсэн толгой;

3.3.2.баталсан он, сар, өдөр (араб тоогоор бичнэ);

3.3.3.тогтоолын дугаар;

3.3.4.тогтоол баталсан газар (хот)-ын нэр;

3.3.5.тогтоолын нэр: тухайн асуудлыг товч байдлаар томьёолсон агуулгыг тусгаж “… тухай” гэж төгсөнө;

3.3.6.тэмдэглэх хэсэг: тогтоол гаргах үндэслэл, шаардлага болон шийдвэр гаргах үндэслэл болох хуулийн нэр, хуулийн холбогдох заалтыг тусгасан байна (*Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсэг гэх мэт*);

3.3.7.тогтоох хэсэг: энэ аргачлалын 2.1-д заасан шаардлагад нийцүүлэн шийдвэрлэх асуудлыг хууль тогтоомж, өмнө гарсан шийдвэрт хэрэглэсэн үг хэллэг, нэр томьёо ашиглан энгийн, ойлгомжтой, хоёрдмол утгагүй байдлаар томьёолж бичнэ;

3.3.8.захирамжилсан шийдвэрийн заалтыг үйл үгийн захиран тушаах хэлбэрээр томьёолсон байна;

3.3.9.шаардлагатай бол өмнө гарсан шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай заалтыг тусгана *(өмнө гарсан шийдвэрийн нэр, баталсан он, сар, өдөр, дугаарыг бүтнээр бичнэ)*;

3.3.10.шаардлагатай бол тогтоол хүчин төгөлдөр болох хугацааг заасан байна.

3.4.Тогтоолын төслийн бүтцийн үндсэн нэгж нь заалт байх бөгөөд шаардлагатай тохиолдолд түүнийг дэд заалтад хувааж болно.

3.5.Энэ аргачлалын 3.3.9-д заасны дагуу өмнө гарсан тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулахад Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан хууль зүйн техникийн шаардлагыг баримтлах бөгөөд дараах дарааллаар байрлуулна:

3.5.1.нэмэлт оруулах;

3.5.2.зарим заалтыг өөрчлөн найруулах;

3.5.3.зарим нэр томьёо, үг, өгүүлбэрийг өөрчлөх;

3.5.4.зарим үг, өгүүлбэрийг хасах;

3.5.5.тогтоол, заалтыг хүчингүй болсонд тооцох.

3.6.Тогтоолын төслийн тогтоох хэсгийг боловсруулахад дараах зарчмыг баримталбал зохино:

3.6.1.төслөөр шийдвэрлэхээр, эсхүл зохицуулахаар тусгасан асуудлын хүрээг бүрэн хамарсан байх;

3.6.2.төслөөр зохицуулахаар тусгасан асуудалд үл хамаарах, эсхүл тухайн асуудлаас хальсан асуудлыг тусгаагүй, тусгасан асуудал нь зайлшгүй шаардлага бүхий, зорилгодоо хүрэхэд тохирсон байх;

3.6.3.төсөлд хууль, бусад шийдвэрийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийх;

3.6.4.хүний эрх, эрх чөлөөнд нөлөөлөх зохицуулалт тусгасан бол тогтоолын хүний эрхэд нөлөөлөх байдлыг тооцоолсон, ялгаварлан гадуурхах шинжгүй байх;

3.6.5.тогтоолыг дагаж мөрдүүлснээс үүсэж болзошгүй үр дагаврыг урьдчилан тооцоолсон, тэдгээр үр дагаврыг зохицуулах, шийдвэрлэх талаарх зохицуулалтыг тусгасан байх;

3.6.6.өмнө гарсан тогтоолыг шинэчлэн батлах, өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн тогтоолын дагуу эрх, үүрэг үүссэн этгээдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шаардлагатай гэж үзвэл шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгах;

3.6.7.гадаад улсын нэрийг бүтнээр бичиж, аймаг, сумдын нэрийг цагаан толгойн үсгийн дарааллын дагуу байрлуулах.

3.7.Тогтоолын төсөл хавсралттай байж болох бөгөөд энэ тухай заалтыг “… -ыг хавсралт ёсоор баталсугай.”, эсхүл “…-ыг 1, 2, 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай” гэж томьёолно.

Жишээ 1:

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ТОГТООЛ

..... оны ..... дугаар сарын ..... –ны өдөр	Дугаар . . .	Улаанбаатар хот

..... тухай

..... тухай хуулийн ..... дугаар зүйлийн ..... дэх хэсэг/заалт-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.....журмыг хавсралт ёсоор баталсугай.

2.....журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ..... үүрэг болгосугай.

ЭСХҮЛ

3. …. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг доор дурдсан Засгийн газрын гишүүд болон холбогдох бусад албан тушаалтнуудад тус тус даалгасугай:

3.1. …
3.2. …

3.8.Тогтоолын хавсралтын эхний хуудасны баруун дээд буланд “Засгийн газрын ... оны … дугаар/дүгээр сарын ...-ны/ний өдрийн ... дугаар тогтоолын хавсралт”, эсхүл “Засгийн газрын ... оны … … дугаар/дүгээр сарын ...-ны/ний өдрийн дугаар тогтоолын … дугаар/дүгээр хавсралт” гэж заана.

3.9.Тогтоолын төслийн заалтыг баруун талдаа цэгтэй араб тоогоор (1., 2., 3. гэх мэт), дэд заалтыг тухайн заалтын дугаарыг үргэлжлүүлэн араб тоогоор (1.1., 1.2., 1.3. гэх мэт) дугаарлана.

Дөрөв.Ерөнхий сайдын захирамжийн төсөл боловсруулах

4.1.Ерөнхий сайдын захирамжийн төслийг Ерөнхий сайдын бүрэн эрхэд хамаарах нэг удаагийн шинжтэй буюу шуурхай шийдвэрлэх шаардлагатай дараах асуудлаар боловсруулна:

4.1.1.хууль тогтоомжид Ерөнхий сайдын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэхээр заасан асуудал;

4.1.2.холбогдох асуудлаар санал, дүгнэлт, шийдэл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг, комисс, зөвлөл зэргийг байгуулах;

4.1.3.Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайдыг шүүхэд төлөөлөн оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилох;

4.1.4.Монгол Улс, Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Олон улсын гэрээний тухай хуульд заасан журмын дагуу олон улсын гэрээнд гарын үсэг зурах эрхийг олгох болон холбогдох албан тушаалтан, байгууллагад үүрэг, чиглэл өгөх;

4.1.5.Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагагүй, хууль тогтоомжид заасан бусад асуудал.

4.2.Ерөнхий сайдын захирамжийн төслийг боловсруулахад энэ аргачлалын 3 дахь хэсэгт заасан шаардлагыг баримтлах бөгөөд бүтцийн хувьд дараах ерөнхий шаардлагыг хангасан байна:

4.2.1.“Монгол Улсын Ерөнхий сайдын захирамж” гэсэн толгой;

4.2.2.баталсан он, сар, өдөр (араб тоогоор бичнэ);

4.2.3.захирамжийн дугаар;

4.2.4.захирамж баталсан газар (хот)-ын нэр;

4.2.5.захирамжийн төслийн нэр: тухайн асуудлын товч байдлаар томьёолсон агуулгыг “… тухай” гэж төгсөнө;

4.2.6.шаардлагатай бол тэмдэглэх хэсэг: уг захирамж гаргах үндэслэл, шаардлага болон шийдвэр гаргах үндэслэл болох хуулийн нэр, хуулийн холбогдох заалт;

4.2.7.захирамжлах хэсэг: энэ аргачлалын 2.1-д заасан шаардлагад нийцүүлэн шийдвэрлэх асуудлыг хууль тогтоомж, өмнө гарсан шийдвэрт хэрэглэсэн үг хэллэг, нэр томьёо ашиглан энгийн, ойлгомжтой, хоёрдмол утгагүй байдлаар томьёолж бичнэ.

Жишээ 2:

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

..... оны ..... дугаар Дугаар . . . Улаанбаатар
сарын ..... –ны өдөр хот

Ажлын хэсэг байгуулах тухай

1.....үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Жишээ 3:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

..... оны ..... дугаар Дугаар . . . Улаанбаатар
сарын ..... –ны өдөр хот

..... тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, ... хуулийн ..... дугаар зүйлийн ..... дахь хэсэг/ заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.....(авах арга хэмжээгээ дурдах)
2.....

Тав.Засгийн газрын шийдвэрийн төсөлд санал авах

5.1.Хууль болон энэ аргачлалд өөрөөр заагаагүй бол энэ аргачлалын 2, 3 дахь хэсэгт заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан шийдвэрийн төсөлд Засгийн газрын бүх гишүүн, шийдвэрийн төсөлд заасан асуудлыг хариуцсан холбогдох байгууллагын саналыг авсан байна.

5.2.Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх хууль тогтоомжийн болон захиргааны хэм хэмжээний актын төслийг Иргэдийн санал, санаачилгыг хүлээн авах Монгол Улсын Засгийн газрын цахим систем (e-zasag.mn)-д хуульд заасан хугацаагаар байршуулж иргэдийн саналыг авсан байна.

5.3.Засгийн газрын шийдвэрийн төслийг санаачилсан Засгийн газрын гишүүн дараах асуудлаарх шийдвэрийн төсөлд доор дурдсан журмын дагуу заавал санал авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгана:

5.3.1.хууль тогтоомжийн төсөл Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, захиргааны хэм хэмжээний актын төсөл хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний;

5.3.2.олон улсын гэрээний төсөл хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх болон Засгийн газрын гишүүний гадаад томилолттой холбогдох асуудалд гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний;

5.3.3.төсөв, хөрөнгө, санхүү болон нэмэлт хөрөнгө шаардагдах асуудлын нийгэм, эдийн засаг (улсын төсөв, хөрөнгө оруулалт, бизнес эрхлэгчид, бараа, бүтээгдэхүүний үнийн түвшин)-т үзүүлэх нөлөөллийн эдийн засгийн тооцоо, судалгааны талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний;

5.3.4.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний;

5.3.5.Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэрийн төсөлд бодлогын хүрээнд нь хамаарч байгаа төрийн захиргааны төв байгууллагын.

5.4.Дараах асуудлаарх шийдвэрийн төсөлд доор дурдсан байгууллагын саналыг заавал авна:

5.4.1.Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах, төрийн болон албаны нууцыг харилцан солилцох, хамгаалах тухай Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр байгуулах, мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцыг шилжүүлэх, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах болон Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэр нь үндэсний аюулгүй байдлыг хөндөж байгаа бол тухайн асуудлаар Тагнуулын ерөнхий газрын;

5.4.2.Нийслэл Улаанбаатар хоттой холбогдох асуудалд Нийслэлийн Засаг даргын, аймаг, сум, орон нутгийн эрх ашиг хөндөгдөх шийдвэрийн төсөлд тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга, шаардлагатай бол нутгийн өөрөө удирдах байгууллагын;

5.4.3.төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах, хууль тогтоомжид заасны дагуу төрийн өмчтэй холбогдох асуудлаар гаргах шийдвэрийн төсөлд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын;

5.4.4.зохицуулах харилцаа нь бусад захиргааны байгууллагын чиг үүрэгт давхар хамаарч байгаа бол тухайн захиргааны байгууллагын;

5.4.5.мэргэжлийн үйл ажиллагаа, мэргэжлийн стандарт, мэргэшлийн шаардлагатай холбоотой асуудлаарх шийдвэрийн төсөлд тухайн салбарын мэргэжлийн нэгдсэн холбооны;

5.4.6.шаардлагатай бол хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах зохицуулалт бүхий шийдвэрийн төсөлд Хүний эрхийн Үндэсний Комиссын, Эрүүгийн хууль, Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбогдсон шийдвэрийн төсөлд Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын;

5.4.7.газар, газрын харилцаа, газар зохион байгуулалт, кадастр, газар ашиглалт, эзэмшил, өмчлөлтэй холбоотой асуудлаарх шийдвэрийн төсөлд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын.

5.5.Захиргааны хэм хэмжээний актын төсөлд уг шийдвэрийн улмаас ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас санал авна. Саналыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн албан бичиг, уулзалт, хэлэлцүүлэг, санал асуулга, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон тухайн байгууллагын цахим хуудсаар дамжуулан авч болно.

5.6.Шийдвэрийн төсөлд холбогдох төрийн бус байгууллагын саналыг авах, хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргуулж болно.

5.7.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ аргачлалын 5.1, 5.3, 5.4-т заасан байгууллага, албан тушаалтан нь төслийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 8 өдөрт багтаан санал өгнө.

5.8.Энэ аргачлалын 5.1, 5.4-т заасан байгууллага, албан тушаалтан энэ аргачлалын 5.7-д заасан хугацаанд багтаан санал ирүүлээгүй бол зарчмын өөр саналгүйд тооцно.

5.9.Ерөнхий сайд Засгийн газрын хуралдаанаар яаралтай хэлэлцүүлэх чиглэл өгсөн асуудалд ажлын 2 өдөрт багтаан санал өгнө.

5.10.Хууль тогтоомжийн төсөлд санал өгөхдөө Хууль тогтоомжийн тухай хуулийн 20.1-д заасан хугацааг баримтална.

5.11.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд холбогдох төрийн захиргааны төв байгууллага ажлын 15 өдөрт багтаан саналаа өгнө.

5.12.Шийдвэрийн төсөл нь “Засгийн газрын хуралдааны журам”-ын 10.3.1, 10.3.2-т заасан асуудалд хамаарах бол энэ аргачлалын 5.1, 5.2, 5.4-5.9-д заасныг баримтлахгүй байж болно. Шаардлагатай тохиолдолд Засгийн газрын гишүүн саналаа Засгийн газрын хуралдаан дээр илэрхийлнэ.

5.13.Шийдвэрийн төсөл боловсруулсан Засгийн газрын гишүүн нь ирүүлсэн саналыг саналын товьёгт нэгтгэхдээ Засгийн газрын гишүүдийг Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд зааснаар эрэмбэлж, санал тус бүрийг төсөлд тусгасан эсэхийг товьёгт тусгана. Хэрэв саналыг тусгаагүй бол энэ талаарх үндэслэлээ санал тус бүрээр тодорхой тусгана.

Жишээ 4:

САНАЛЫН ТОВЬЁГ

№	Засгийн газрын гишүүд болон холбогдох байгууллагын нэрс	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан байдал
1.	Засгийн газрын гишүүдийг Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд заасан дарааллаар бичих	Саналыг бүрэн бичих	Саналыг “тусгасан эсхүл, тусгаагүй” гэж хэт ерөнхий байдлаар бичихгүй. Харин өгсөн санал тус бүрийг төсөлд хэрхэн тусгасан, эсхүл, ямар үндэслэлээр тусгаагүй талаар дэлгэрэнгүй тайлбарлан бичнэ.

5.14.Энэ аргачлалын 5.1, 5.3, 5.4-т заасан саналыг аваагүй, эсхүл шийдвэрийн төсөлд тусгаагүй бол үндэслэл, шаардлагыг тайлбарлан шийдвэрийн төслийн танилцуулга болон саналыг товьёгт тусгасан байна.

5.15.Энэ аргачлалын 5.1, 5.3-т заасан төрийн захиргааны төв болон холбогдох байгууллага төсөлд тусгасан асуудлаар зарчмын зөрүүтэй санал ирүүлсэн тохиолдолд шийдвэрийн төслийг холбогдох Засгийн газрын гишүүн, холбогдох байгууллагатай эцэслэн тохиролцож, тухайн асуудлаар нэгдмэл байр сууринд хүрсний үндсэн дээр холбогдох шийдвэрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

5.16.Засгийн газрын шийдвэрийн төслийг боловсруулсан байгууллага нь тухайн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлэхдээ энэ аргачлалын 2.2, 5.13-т заасан материалын хамт, Засгийн газрын гишүүд болон холбогдох байгууллага, албан тушаалтнаас санал авахаар хүргүүлсэн төслийн хувийг заавал хавсаргана.

5.17.Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэл агуулсан бол шийдвэрийн төсөл, түүнд холбогдох материалыг Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох журамд нийцүүлэн нууцын зэрэглэлтэй боловсруулж, нууцын зэрэглэлийн дардсыг зохих журмын дагуу дарсан байна. Шаардлагатай тохиолдолд нууцын зэрэглэлийн талаар Тагнуулын ерөнхий газрын саналыг заавал авч, хавсаргасан байна.

----o0o----

Хаяг:
“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn
Утас: 262420
Хэвлэлийн хуудас: 1.75
Индекс: 200003